



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

НЦС ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/042/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 302

танай _____ -ны № _____ -т

НЦС ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ӨНӨРБАЯР ТАНАА**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу НЦС ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 16,450.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, машин тоног төхөөрөмжийн их засварт 10,914.5 мянган төгрөгийг зарцуулан үндсэн хөрөнгөнд капиталжуулан тус тус бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад 45,869.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050437

Г-12 Байнг хэрэг/2025/БайгСТА-ндүүлэлт/Тэсвэл Огсх

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	28,958,518.15	38,989,647.20
4	Дансны авлага	3,014,406.00	-
5	Татвар, НДШ-ийн авлага	6,205,592.52	-
6	Бусад авлага	-	-
8	Бараа материал	71,274,389.71	70,606,287.78
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	109,452,906.38	109,595,934.98
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө	5,601,228,136.76	5,122,414,700.74
23	Биет бус хөрөнгө	19,946,000.00	19,946,000.00
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,621,174,136.76	5,142,360,700.74
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,730,627,043.14	5,251,956,635.72
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
27	Өр төлбөр	-	-
28	Богино хугацаат өр төлбөр	-	-
29	Дансны өглөг	-	-
30	Цалингийн өглөг	-	-
31	Татварын өр	141,059.00	13,896,496.64
32	НДШ-ийн өглөг	-	-
38	Бусад богино хугацаат өр төлбөр	141,059.00	13,896,507.64
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	141,059.00	13,896,507.64
46	Бусад урт хугацаат өглөг	5,427,119,225.50	4,964,194,387.22
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,427,119,225.50	4,964,194,387.22
49	Өр төлбөрийн нийт дүн	5,427,260,284.50	4,978,090,894.86
50	Эздийн өмч	-	-
51	Өмч: а) төрийн	591,150,021.02	591,150,021.02
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	47,051,732.21	47,051,732.21
58	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	19,946,000.00	19,946,000.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(354,780,994.59)	(384,282,012.37)
61	Эздийн өмчийн дүн	303,366,758.64	273,865,740.86
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,730,627,043.14	5,251,956,635.72

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	485,237,402.26	552,108,685.07
2	Борлуулалтын өртөг	897,522,849.03	948,703,205.76
3	Нийт ашиг	(412,285,446.77)	(396,594,520.69)
5	Хүүний орлого	-	7,338,965.12
7	Нутгийн дэм	28,299,479.80	41,419,471.16
8	Бусад орлого	521,498,178.86	462,924,838.28
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	136,101,619.95	144,589,771.65
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,410,591.94	(29,501,017.78)
19	Орлогын татварын зардал	141,059.00	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	1,269,532.94	(29,501,017.78)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,269,532.94	(29,501,017.78)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Орлогын нийт дүн	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	611,096,021.02	47,051,732.21	(354,780,994.59)	303,366,758.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	(29,501,017.78)	(29,501,017.78)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	611,096,021.02	47,051,732.21	(384,282,012.37)	273,865,740.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	572,818,897.94	691,664,654.67
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	572,818,897.94	691,664,654.67
9	Мөнгөн зарлагын дүн (-)	605,717,008.16	654,269,066.53
10	Ажиллагчдад төлсөн	296,231,273.00	344,476,981.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,863,643.80	108,123,142.41
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	67,419,660.00	55,911,181.91
13	Ашиглалтын зардалд төлсөн	24,206,590.57	38,057,114.13
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	58,242,464.50	56,422,094.00
16	Татварын байгууллагад төлсөн	78,648,513.42	51,178,165.95
18	Бусад мөнгөн зарлага	104,862.87	100,387.13
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,898,110.22)	37,395,588.14
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
21	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
25	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
26	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
30	Мөнгөн зарлагын дүн (-)	-	27,364,459.09
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	27,364,459.09
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
34	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
39	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
40	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
42	Төрөл бүрийн хандив	-	-
44	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
47	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
51	Валютын ханшийн зөрүү	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(32,898,110.22)	10,031,129.05
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,856,628.37	28,958,518.15
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,958,518.15	38,989,647.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт борлуулалт	1,144,019,902.00	1,063,791,959.63	(80,227,942.37)	93.0
Үйл ажиллагааны орлого	465,246,922.00	508,581,671.37	43,334,749.37	109.3
Хог зөөврий орлого	84,000,000.00	43,527,013.70	(40,472,986.30)	51.8
Ариутга татуурга	40,037,298.40	7,338,965.12	(32,698,333.28)	18.3
Нутгийн дэм	33,813,444.00	41,419,471.16	7,606,027.16	122.5
Үйл ажиллагааны бус орлого /хөрөнгийн элэгдэл/	520,922,237.60	462,924,838.28	(57,997,399.32)	88.9
Нийт зардал	1,176,934,083.00	1,093,292,977.41	(83,641,105.59)	92.9
Үйлвэрийн ажилчдын НДШ байгууллагаас	53,373,320.00	52,371,441.50	(1,001,878.50)	98.1
Тээвэрийн зардал	66,420,000.00	44,956,049.00	(21,463,951.00)	67.7
Хөдөлмөр хамгаалалын зардал	7,760,000.00	5,082,443.74	(2,677,556.26)	65.5
Цахилгаан ашиглалтын зардал	33,946,250.00	18,237,850.86	(15,708,399.14)	53.7
Шатхууны зардал	18,162,548.00	12,258,111.23	(5,904,436.77)	67.5
Мэргэжлийн үйлчилгээний зардал	11,900,000.00	14,189,388.58	2,289,388.58	119.2
Сэлбэгийн зардал	25,130,000.00	14,613,082.37	(10,516,917.63)	58.1
Ажилчдын үйлдвэрлэлийн цалин	381,238,000.00	404,247,179.00	23,009,179.00	106.0
Бусад зардал	14,000,000.00	5,442,089.00	(8,557,911.00)	38.9
Хойшлогдсон хөрөнгийн элэгдэл	537,962,365.00	502,429,447.65	(35,532,917.35)	93.4
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	9,572,000.00	2,617,929.13	(6,954,070.87)	27.3
Томилолтын зардал	3,560,000.00	2,920,000.00	(640,000.00)	82.0
Бичиг хэргийн зардал	3,600,000.00	2,308,542.22	(1,291,457.78)	64.1
Сургалтын зардал	10,000,000.00	11,519,036.00	1,519,036.00	115.2
Банкны зардал	309,600.00	100,387.13	(209,212.87)	32.4
Нийт ашиг	(32,914,181.00)	(29,501,017.78)	3,413,163.22	89.6
Орлогын татвар	-	-	-	-
Цэвэр ашиг	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад 44.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангийн тодруулгад бараа материалын эцсийн үлдэгдлийн дүнг 26.8 сая төгрөгөөр дутуу тусгасан;
- Санхүүгийн тайлангийн тодруулгад богино хугацаат өр төлбөр 13.9 сая төгрөгийг тусгаагүй;
- Бараа материалын түүвэр тооллогоор 2.6 сая төгрөгийн шаардахаар гарсан бараа материалын зарлагыг бүртгэлд тусгаагүй, 0.8 сая төгрөгийн принтерийг бараа материалаар бүртгэсэн байна.

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.8 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11.7 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Тус байгууллага нь 3.8 сая төгрөгийн зөөврийн компьютерийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмж, материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн уялдаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлан, түүний тодруулгыг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалд заасны дагуу иж бүрэн бэлтгэж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулгыг хуульд заасан хугацаанд, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэж байхыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайлангийн тодруулгад бараа материалын эцсийн үлдэгдлийн дүнг 26,841.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	1	26,841.0	-	-	1	26,841.0	1	26,841.0	-	-	-	-
2	Санхүүгийн тайлангийн тодруулгад богино хугацаат ер төлбөр 13,896.5 мянган төгрөгийг тусгаагүй.	1	13,896.5	-	-	1	13,896.5	1	13,896.5	-	-	-	-
3	Бараа материалын түүвэр тооллогоор 2,585.0 мянган төгрөгийн шаардахаар гарсан бараа материалын зарлагыг бүртгэлд тусгаагүй, 789.5 мянган төгрөгийн принтерийг бараа материалаар бүртгэсэн.	1	3,374.5	-	-	1	3,374.5	1	3,374.5	-	-	-	-
	Дүн	3	44,112.0	-	-	3	44,112.0	3	44,112.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Тус байгууллага нь 3,800.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерын худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй байна	1	3,800.0	-	-	1	3,800.0	-	-	-	-	-	-
2	Санхүүгийн тайлан, түүний тодруулгыг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалд заасны дагуу иж бүрэн бэлтгэж ажиллаагүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	2	3,800.0	-	-	1	3,800.0	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд 21.2 сая төгрөгийн аюулгүй ажилласны нэмэгдлийг олгосон бөгөөд Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д аюулгүй ажилласны нэмэгдэл олгох талаар тусгай заалт байхгүй байна.	1	21,238.3	-	-	-	-	1	21,238.3
	Дүн	1	21,238.3	-	-	-	-	1	21,238.3